

# **ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭЭЛЖИТ НАЙМ, ЕСДҮГЭЭР ИЛТГЭЛ**

## **УДИРТГАЛ ХЭСЭГ Хуудас 3-5**

1. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай

Конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын Засгийн газрын  
ээлжит найм, есдүгээр илтгэлийн тайлбар

1. Монгол улсын талаарх ерөнхий танилцуулга

## **I ХЭСЭГ Хуудас 5-15**

1.1 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг хориглосон хууль  
тогтоомж, түүний дагуу авсан арга хэмжээ (Конвенцийн 2,3-р зүйл)

1.2 Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүргийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд  
хийгдсэн үйл ажиллагаа (Конвенцийн 5-р зүйл)

1.3 Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг  
таслан зогсоход авсан арга хэмжээ (Конвенцийн 6-р зүйл)

## **II ХЭСЭГ Хуудас 15-18**

2.1 Улс төр, нийгмийн амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцох  
боломжийг хангасан байдал (Конвенцийн 7,8-р зүйл)

2.2 Эмэгтэй, эрэгтэй хүн, хүүхдэд иргэний харъяаллын тухайд тэгш эрх олгосон  
байдал (Конвенцийн 9-р зүйл)

## **III ХЭСЭГ Хуудас 18-30**

3.1 Боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт

(Конвенцийн 10-р зүйл)

3.2 Хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт  
(Конвенцийн 11-р зүйл)

3.3 Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт

(Конвенцийн 12-р зүйл)

3.4 Эдийн засаг, нийгмийн хамгааллын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 13-р зүйл)

3.5 Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг анхааран үзсэн байдал (Конвенцийн 14-р зүйл)

#### IV ХЭСЭГ Хуудас 30-32

4.1 Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хуулийн өмнө болон иргэний харилцаанд адил тэгш эрх, чадамжтай байх эрхийн хэрэгжилт (Конвенцийн 15-р зүйл)

4.2 Гэрлэлт, гэр бүлийн харилцаа дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 16-р зүйл)

#### ХАВСРАЛТУУД Хуудас 33-50

Хавсралт 1. 2004-2014 оны хүйсээр ангилсан статистик мэдээллийн эмхтгэл

Хавсралт 2. Монгол улсын тав, зургаа, долоодугаар тогтмол тайлан илтгэлд Конвенцийн Хорооны 54-р хуралдаанаас гаргасан ажиглалтын дүгнэлтийн хариулт

#### УДИРТГАЛ ХЭСЭГ

1. i. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын Засгийн газрын илтгэлийн тайлбар

Монгол улсын Засгийн газраас Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн (Цаашид “Конвенц” гэнэ.) хэрэгжилтийн талаарх тав, зургаа, долоодугаар илтгэлийг хамтатган 2008 оны 9 дүгээр сард хүргүүлж, хэлэлцүүлсэн. (CEDAW/C/SR.858 and 859) Тус илтгэлдээ 2000-2004 оны тоо баримт, статистик мэдээллийг ашиглан, Конвенцийн хэрэгжилттэй холбоотой нөхцөл байдлыг танилцуулсан байдаг бөгөөд илтгэлтэй холбоотой гаргасан Конвенцийн Хорооны дүгнэлт, зөвлөмжийн (CEDAW/C/MNG/CO/7/08-57534(E)301008) дагуу энэ удаагийн 8,9 дүгээр илтгэлд статистик мэдээлэл, баримт жишээг 2004-2009, 2010-2014 онуудаар зааглан, хамруулан оруулсан ба нарийвчилсан статистик мэдээллийг нэмэлтээр хавсаргасан.

Тус илтгэлийг бэлтгэх ажлын хэсгийг Монгол улсын Ерөнхий сайдын 2014 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 77 дугаар захирамжаар байгуулж, захирамжийн дагуу Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын алба энэхүү илтгэлийг бэлтгэх ажлыг удирдан зохион байгуулсан. Илтгэлийг төрийн болон иргэний нийгмийн, олон улсын байгууллагууд, үндэсний зөвлөхүүдийн хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан гаргасан болно. Илтгэлд Бээжингийн тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтуудын хүрээнд үндэсний түвшинд дэвшүүлсэн

зорилтууд, олсон амжилт, тулгарч буй бэрхшээлийг конвенцийн зүйл заалттай уялдуулан тусгасан.

Мөн энэхүү тайлантай хамтруулан Конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын тав, зургаа, долоодугаар тогтмол тайлан илтгэлд (CEDAW/C/SR.858 and 859) Конвенцийн Хорооны 54-р хуралдаанаас гаргасан (CEDAW/C/MNG/CO/7/08-57534(E)301008) ажиглалтын дүгнэлтийн хариултыг хүргүүлж байна.

Монгол улс эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг буруушаан, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг устгах Конвенцийн үзэл санааг үндэсний бодлого, хууль тогтоомж, хөтөлбөртөө тусган, хэрэгжүүлж ирсэн бөгөөд цаашид ч илүү хүчин чармайлт гаргах болно.

1. ii. Монгол улсын талаарх ерөнхий танилцуулга
  1. Монгол улс нь Төв Азийн эх газар, хойд талаараа Оросын холбооны улстай, урд талаараа БНХАУ-тай хил залган оршдог. Нийт 1.5 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай, засаг захиргааны хувьд 21 аймаг нь 362 суманд, нийслэл нь 9 дүүрэгт хуваагддаг.
  2. Монгол улс 2.9 сая хүн амтай, нийт хүн амын 51.3 хувь нь эмэгтэйчүүд, 48.7 хувь нь эрэгтэйчүүд, хүн амын жилийн дундаж өсөлт 1.4 хувьтай байна. Дундаж наслалт 2013 онд 69.1 жил, эмэгтэйчүүдийнх 75.0, эрэгтэйчүүдийнх 65.4 байна.
  3. Хүн амын 67.2 хувь нь хот, суурин газарт амьдарч, сүүлийн арван жилд хөдөөгөөс хот суурин газарт шилжих хөдөлгөөн эрчимжиж, хотын хүн амын тоо эрс нэмэгдэж байна.
  4. Монгол улсын хүний хөгжлийн индекс 0.787 байна. Жендэрийн хөгжлийн индекс (GDI) 2005 онд 0.677, 2013 онд 0.791, Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр (GEM) 2005 онд 0.388, 2013 онд 0.529 болсон.

Эдийн засаг, нийгмийн байдал

1. Монгол улс чөлөөт зах зээлийн эдийн засагт амжилттай шилжиж, сүүлийн 10 жилийн дотор уул уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлснээр төсвийн орлого огцом нэмэгдэж, 2011 онд эдийн засгийн өсөлт 17.3 хувьд хүрч урьд өмнө байгаагүй амжилтанд хүрсэн. Гэсэн хэдий ч инфляцийн түвшин хоёр оронтой тооноос буурахгүй байна. 2014 оны эхний хагас жилд ДНБ өсөлт 5.3 хувь, ажилгүйдлийн түвшин 8,4 хувь, инфляцийн түвшин 14.9 хувьтай байна.
2. 2011-2012 оны Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд “Монгол улс нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний хувьд үйлдвэрлэлийн хүчин зүйлсэд тулгуурласан хөгжлийн нэгдүгээр үе шатнаас бүтээмжид суурилсан хоёрдугаар шатанд шилжиж байгаа улс” гэж тэмдэглэсэн ба Монгол улс дунджаас доогуур орлоготой орнуудын ангилалд багтан орсон.
3. Хэдийгээр эдийн засгийн өсөлтийг ерөнхийд нь авч үзэхэд ахиц дэвшил гарч байгаа дүр зураг ажиглагддаг ч, эдийн засгийн өсөлтийн үр дүн, үр нөлөө,

хүртээмж нь эмэгтэйчүүдэд болон нийгмийн эмзэг бүлгийн хүн амд төдийлөн ээлтэй байж чадахгүй байна.

4. Сүүлийн 10 жилд эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувь тасралтгүй өсч, цаашид ч нэмэгдэх төлөвтэй байна. Монгол улс эдийн засгийн шинэ давалгаа болох газрын баялагаа олборлон ашиглах сонголтыг хийснээр түүнийг даган олон салбарууд шинээр эрчимтэй хөгжих эерэг хандлагатай байгаа ч, байгаль орчин болон нийгэм, улс төрийн олон сөрөг эрсдлийг бий болгож байна. Үүний нэг том эрсдэл нь ашигт малтмал олборлолт явуулж буй газруудад нутгийн иргэд, үйлдвэрлэлд нь хяналт тавих эрх мэдэлгүй байгаа төдийгүй уул уурхайн үйл ажиллагаанаас нутгийн байгаль орчинд үзүүлсэн хор хохирлыг үүрч байгаа явдал юм.
5. Статистик мэдээллээр ядуурлын түвшин 2010 онд 38.7 хувьд хүрч хамгийн өндөр байсан ба жил тутамд буурч 2012 оны эцсийн дүнгээр 27.4 хувь болсон. Үүнээс хөдөөд 35.5 хувь хот, суурин газарт 23.2 хувьтай байна. Ядууралд өртөж байгаа хүн амын нөхцөл байдал ялгаатай байна. Жишээлбэл, хөдөөд эрэгтэйчүүд, хот суурин газар эмэгтэйчүүд илүү ядууралд өртөж, өрхийн тэргүүн нь боловсрол муутай өрхийн 48 хувь нь ядуу байна.

10. Өрх толгойлсон хүний тоо 107.2 мянга болж 2004 онтой харьцуулахад 22.9 мянгаар нэмэгдсэн. Үүнээс эмэгтэйчүүд толгойлсон өрх 76.2 хувийг эзэлж байна. 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 39.9 мянга байна. 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн 60 гаруй хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна.

11. 2013 оны цагдаагийн статистик мэдээллээс авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 623 бүртгэгдсэний 54.8 хувь нь хотод, 45.2 хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн дийлэнх нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байна.

## I ХЭСЭГ

1.1 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг хориглосон хууль тогтоомж, түүний дагуу авсан арга хэмжээ

(Конвенцийн 2,3-р зүйл)

12. Монгол улс эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг буруушаан, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг устгах Конвенцийн заалтыг үндэсний бодлого, хууль тогтоомж, хөтөлбөртөө тусган, хэрэгжүүлж ирсэн.

13. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүн тэгш эрхтэй”, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” (14.2), “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын

амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. (11), “Хүн бүр эрх зүйн этгээд байна”, “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” (14.1), Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ, Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж тус тус заасан.

14. Монгол Улсын Их хурлаас 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг баталсан нь Үндсэн хуулийн дээрх заалтуудыг эрх зүйн хүрээнд улам баталгаажуулж, эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах хууль, эрх зүйн орчинг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэхэд томоохон ахиц болсон.

15. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай(2011), Гэр бүлийн тухай (1999), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2004), Хүн худалдаалахтай тэмцэх тухай (2012) хуулиудаар хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийг хангаж баталгаажуулан, төрийн бүх шатны байгууллагууд, аж ахуйн нэгж болон бусад холбогдох талуудын бүрэн эрх, үүргийг нарийвчлан тусгасанаараа чухал ач холбогдолтой хууль болж байна.

16. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилго бүхий Монгол улсын Засгийн газрын дунд хугацааны стратегийг (2013-2016) 2013 оны 1 дүгээр сард баталсан. Тус стратегид салбаруудын бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох, хуулийг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэх зорилтыг тодорхойлсон. Монгол улс анх удаа хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын стратеги баталсан нь тус хуулийг хэрэгжүүлэхэд салбар дундын шинж чанартай олон зохицуулалтууд шаардлагатай болсонтой холбоотой.

17. Дээрх стратегид бүх шатны бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг жендэрийн статистик, дүн шинжилгээнд тулгуурлан хийхээр заасан бөгөөд салбар бүрээр жендэрийн мэдээллийн санг бүрдүүлэн, статистик мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх арга зүйг нэвтрүүлэх ажлыг хийхийг төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн засаг захиргаанд үүрэг болгосон.

18. Үүнтэй уялдуулан Үндэсний статистикийн хорооноос (ҮСХ) 2013 оны 9 сард Монгол улсын жендэрийн статистикийн суурь үзүүлэлтүүд, түүний хүрээг баталсан. ҮСХ нь Жендэрийн статистикийн суурь үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг боловсруулах, салбарын яамдыг жендэрийн статистик мэдээллийн сантай холбох ажлыг хийж байна. Үндэсний хэмжээнд жендэрийн асуудлаар хүйсээр ангилсан тоон мэдээллийн сан бүрдүүлэх нь Конвенцийн хэрэгжилтийг хянах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын үйл явцыг үнэлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэн цаг хугацааны өөрчлөлийг хариуулах боломжтой “Жендэрийн мэдээлэл” гэсэн нэртэй статистикийн эмхтгэлийг гаргахаар бэлтгээд байна. ҮСХ нь 2013 оноос орон тооны жендэрийн мэргэжилтэнг ажиллуулсан нь Монгол улсад жендэрийн статистикийг хөгжүүлэх, түгээхэд чухал нөлөө үзүүлж байна.

19. Жендэрийн Үндэсний Хорооноос Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн албаны зөвлөл, ҮСХ, Хүний эрхийн Үндэсний комисс, Цагдаагийн байгууллага, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт, шалгалт, үнэлгээний газруудтай Жендэрийн Үндэсний хороотой хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд эмэгтэйчүүд, охидын эрхийг хамгаалах асуудлаар шийдэгдэхэд хүндрэлтэй байсан асуудлуудыг шийдвэрлэх боломж бүрдэж байна.

20. Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд Ерөнхийлөгчийн тамгын газар, Хууль зүйн яам 2013 онд Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг батлахад голлох үүрэгтэй оролцож, хэрэгжүүлэх үүрэг бүхий Тахарын албыг тусгайлан байгуулахад нөлөөлж ажилласан нь хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалахад гэрч хохирогчийн эрх зөрчигддөг шалтгаанаар хэрэг илрэхгүй байх, хохирогч хэргийн талаарх гомдлоо буцаан татах зэрэг саад бэрхшээлүүд тулгарч байсантай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөөлөл үзүүлэх боллоо.

21. Цагдаагийн мэдээлэл судалгааны төвөөс улирал тутамд гэмт хэрэг тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч нь хэн болох, хаана үйлдэгдсэн, хүчирхийллийн хэлбэрээр нь үндэсний хэмжээнд нэгтгэн ЖҮХ-нд тогтмол тайлагнаж, цагдаагийн мэдээллийн санд нэгтгэж байна.

22. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комисст (ХЭҮК) уг хуулийн хэрэгжилт, ахиц дэвшлийн талаар хоёр жил тутамд УИХ-д тайлагнах, жендэрийн ялгаварлан гадуурхалтын асуудлаарх гомдол хүлээн авах, шийдвэрлэх мандатыг олгосон. ХЭҮК нь хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэнд хяналт тавих, хүний эрхийг хамгаалах, хөхүлэн дэмжих хуулиар олгосон чиг үүргийнхээ хүрээнд Конвенцийн хэрэгжилтийг хянахад анхааран ажилладаг. ХЭҮК нь жил бүр Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг УИХ-д өргөн барьж хэлэлцүүлдэг. Хэлэлцүүлгийн дүгнэлтийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны тогтоолоор баталгаажуулан, илтгэлтэй холбоотой асуудлаар авах арга хэмжээг үүрэгжүүлэн албажуулдаг. ХЭҮК нь 2013 онд танилцуулсан 13 дахь илтгэлдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин нь хохирогчийн бодит хамгаалал болж чадахгүй байгаа асуудлыг гаргаж тавьсан. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг шуурхай, үр дүнтэй хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчидэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог оновчтой болгох шаардлагад нийцүүлэх зөвлөмж гаргасан нь хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх шатанд нөлөөллийн үндэслэл болж ашиглагдаж байна.

23. ХЭҮК нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдснаас хойш жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой ажлын байрны бэлгийн дарамт, гэр бүлийн хүчирхийлэлийн асуудлаар 2011 онд 5, 2012 онд 9, 2013 онд 16, 2014 оны 6 сарын байдлаар 9 гомдол нийт 39 гомдол хүлээн авсан. ХЭҮК нь гомдолыг хүлээн авч хохирогчийн эрх, ашгийг шүүхэд төлөөлөн нэхэмжлэх, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцуулах, хохирогчийн эрхийг сэргээлгэхээр холбогдох

байгууллага, албан тушаалтанд ХЭҮК-ын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүргүүлдэг.

24. ХЭҮК нь ял эдлэж буй эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах зорилгоор хүн амины гэмт хэрэгт ял шийтгүүлсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, шүүхийн тогтоолд дүн шинжилгээ хийсэн. Дүн шинжилгээгээр шүүх ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн асуудлыг шийдвэрлэхгүй орхисонг тогтоож, эрх зүйн зохицуулалт хийх санал дэвшүүлсэн. Ял эдлэж байгаа эмэгтэйчүүдийн олонх нь гэр бүлийн хүчирхийлэлд олон жил өртсөн байдаг.

25. ХЭҮК-оос 2014 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11-р зүйлд заасан хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа хэрхэн хангагдаж байгаа байдлыг хянах үүднээс 24 байгууллага, 514 хүнийг хамруулсан бие даасан судалгаа хийсэн. Судалгаагаар ажлын байрны бэлгийн дарамтанд өртсөн хохирогч гомдлоо шийдвэрлүүлж чадахгүй байгаа төдийгүй хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажил олгогчдын хуулийн мэдлэг, мэдээлэл дутмаг, энэ талаарх ажил олгогчийн үүргийг Хөдөлмөрийн тухай хуульд тодорхой тусгаагүй, ялангуяа ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамт үзүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох механизм тодорхой бус байгааг илрүүлсэн байна. Үүнийг ХЭҮК хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2014 оны 13 дахь илтгэлдээ тусган УИХ-д шийдвэр гаргуулахаар өргөн бариад байгаа нь энэ онд УИХ-аар хэлэлцэхээр бэлгэж байгаа Хөдөлмөрийн хуулийн шинэчлэлд чухал нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлж байна.

26. 2005 онд Үндэсний хэмжээний жендэрийн бодлогыг уялдуулан зохицуулах зорилгоор Монгол улсын Ерөнхий сайдаар даргалуулсан Жендэрийн Үндэсний Хороог байгуулж, түүний ажлын албыг шинээр бий болгосон нь эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөлдөх, хяналт тавьж ажиллах үндэсний тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болж байна.

27. Жендэрийн Үндэсний хороо нь орон тооны бус 25 гишүүдтэй, аймаг нийслэлд 22 салбар хороотой, яам, дүүрэгт 25 салбар зөвлөлтэй, бие даасан ажлын албатай. Ажлын алба нь 8 хүний бүрэлдэхүүнтэй. Тус хороо 2005-2009 онуудад жендэрийн бодлого, үзэл баримтлалыг салбарын яамд болон орон нутгийн үйл ажиллагаанд төлөвшүүлэх, улмаар дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудын туршлага судалж, түүнийг иргэд, төр, олон нийтэд хүргэх мэдээллийн сантай болоход ажилаа хандуулж ирсэн. 2011 оноос Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдснаар тус хорооны чиг үүрэг тодорхой болж, хуулийг хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалтуудыг хийх, үндэсний жендэрийн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход үйл ажиллагаа чиглүүлж байна. Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй хүргэх зорилгоор [www.gender.gov.mn](http://www.gender.gov.mn) вэбсайт-ыг ажиллуулж байна.

28. Жендэрийн үндэсний хороо нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор ажлын албаны дэргэд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, Жендэрийн консорциум, Хэвлэл мэдээллийн болон Иргэний нийгмийн зөвшилцөх зөвлөлүүдийг байгуулан ажиллаж байна.

29. Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг нь (National Gender Experts` Group) Монгол улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад гарч буй хүндрэл бэрхшээлийг судлан шинжилж, жендэрийн аудит хийж, бодлогын зөвлөмж гаргах эрх бүхий, жендэрийн эрх тэгш байдлын болон хүний эрхийн асуудлаар мэргэшсэн шинжээчдээс бүрддэг.

30. Жендэрийн консорциум нь жендэрийн боловсролыг дэмжих, жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой эрдэмтэд, их дээд сургуулийн багш, судлаачдын сайн дурын бүлэг юм. Тус консорциум нь Жендэрийн үндэсний хороотой хамтран их дээд сургуулийн оюутангуудын дунд жил бүр жендэрийн асуудлаар эрдэм шинжилгээний баг хурал зохион байгуулдаг ба бүх шатны сургалтын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгох бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

31. Монгол улсад эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахын төлөө ажилладаг эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь хүчтэйд тооцогддог. Монгол улсад эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах үйлст Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын оруулсан хувь нэмэр, нөлөө томоохон байр суурийг эзэлдэг.

32. Түүнчлэн жендэрийн талаарх олон нийтийн ойлголт, стереотипийг өөрчлөх, гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэхэд НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Швейцарийн хөгжлийн агентлаг, болон бусад хамтын ажиллагааны нийгэмлэг, төрөлжсөн байгууллагууд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

33. Монголд жендэрт суурилсан хүчирхийллийн дараах хэлбэрүүд илүү түгээмэл байна. Үүнд: гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, ажын байран дахь бэлгийн дарамт болно. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах тухай заалт байдаг ч хэрэгжүүлэх механизм байхгүй, үйл ажиллагааны зардал төсөвт суугаагүйн улмаас бодит амьдралд хохирогчийг хамгаалах хамгаалалт болж чадахгүй байна гэсэн шүүмжлэл гарсаар байна.

34. Сүүлийн 3 жилд 49 хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас амиа алдаж, 1180 хүн гэмтсэн мэдээлэл байгаа бөгөөд хохирогчдын 86.6 хувь нь эмэгтэйчүүд байжээ. (Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл судалгааны төвийн мэдээлэл) Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдсэний дотор хүчиндэх гэмт хэрэг 3.8 хувийг эзэлж байна. Хүчингийн гэмт хэргийн хохирогч 72 хүүхдийн 33 хувь нь хойд



эцэгтээ, 59 хувь нь ах дүү, хамаатан садандаа, 8 хувь нь танихгүй хүнд хүчиндүүлсэн байна. (Нэг цэгийн үйлчилгээнүүдийн мэдээ, 2010.1.01–2011.5.25) Гэвч өнөөгийн байдлаар ураг төрлийн хүчингийн гэмт хэргийг бусад нөхцөлд үйлдэгдсэн хүчингийн гэмт хэрэгтэй адилтган шийдвэрлэж байгаагаас ихэнх хэрэг “нотлогдоогүй” гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болсоор байгаад анхаарал хандуулж ажиллаж байна.

35. Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан Хууль зүйн яам ажлын хэсэг байгуулан төрийн бус байгуулагуудын оролцоотойгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн төслийг боловсруулж УИХ-д өргөн бариад байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, шуурхай үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрх, хамгааллыг сайжруулах зорилгоор 1222, Хүүхдийн утас-108 тусгай дугааруудыг 24 цагаар ажиллуулж байна.

36. Нийгмийн халамжийн сангаас гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байранд байх хугацааны зардлыг хариуцаж байгаа ба хамгаалах байранд тавигдах стандартыг баталсан. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ноогдох хувьсах зардал 2010 онд 9000 төгрөг байсан бол 2014 онд 19.150 төгрөг болж өсгөсөн. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний 3 төвийг Улаанбаатар хотод байгуулсан. Засгийн газар хөрөнгө санхүүжилтийн хязгаарлагдмал байдлаараас шалтгаалан УБ хотод байрладаг нэг л хамгаалах байрны зардлыг хариуцан ажиллаж байна. Цаашид улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хамгаалах байрууд болон нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд төсвөөс санхүүжилт олгоход анхааран ажиллах шаардлага Засгийн газрын өмнө тулгарч байна.

37. 2004-2007 онд шүүхээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн заалтыг хэрэглэж 41 шийдвэр гаргасан. Гэхдээ шүүхийн шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх процедур хуульчлагдаагүй, хэрэгжүүлэх механизм байхгүйгээс шүүхийн шийдвэр хэрэгжих ямар ч боломжгүй байна. Нэг тохиолдлыг дурьдахад “2012 оны 4-р сарын 5–ны өдөр 22 настай эмэгтэй Г нөхөртөө 12 удаа хутгалуулж нас барсан. Тэрээр гэрлэсэн цагаасаа эхлэн нөхрийнхөө байнгын дарамт, хүчирхийлэл дор амьдарч байсан бөгөөд хүчирхийлэл дарамтаас салахын тулд олон байгууллагаар явсны эцэст хуулийн хамгаалалт авч чадалгүй амиа алдсан. Хэдийгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай бие даасан хууль үйлчилж байгаа боловч энэ эмэгтэйг хамгаалж чадаагүй. Энэ эмэгтэйн амь насаа алдахад хуулийн цоорхой, хуульчид, мэргэжилтнүүдийн мэдрэмжгүй хандлага нөлөөлсөн” гэж эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцдэг байгууллагууд үзсэн. (Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ мэдээлэл, 2014 он) Иймд Засгийн газраас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоход илүү анхаарч, бодлогын түвшинд хамтран ажиллаж байна.

1.2 Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөх

(Конвенцийн 5-р зүйл)

38. Засгийн газар Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд эмэгтэйчүүдийг дорд үзэх, ялгаварлах хэвшмэл ойлголтыг өөрчлөх зорилгоор олон нийтэд зориулсан ухуулга сурталчилгааг өрнүүлэх, түүндээ хэвлэл мэдээллийг татан оролцуулахад анхааран ажиллаж байна. Тухайлбал, ЖҮХ нь дэргэдээ хэвлэл, мэдээллийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн “Хэвлэл мэдээллийн зөвлөл” байгуулан, төлөвлөгөө гарган хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд “Глоб Интернэйшл” ТББ-тай хамтран “Хэвлэл мэдээллийн салбар дахь жендэрийн шалгуур үзүүлэлтүүд” бүхий гарын авлагыг хэвлэж олон нийтийн телевиз, өдөр тутмын сонингуудын үйл ажиллагаанд туршиж эхлээд байна.

39. Засгийн газраас жил бүр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг угтан эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх 7 хоногийн аянг бүх нийтийн дунд тогтмол зохион байгуулж ирсэн. Энэхүү үйл ажиллагаанд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр байнга дэмжлэг үзүүлэн хамтран ажилладаг.

40. Гэр бүлийн болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд эрэгтэйчүүдийн оролцоог хангах асуудлыг хөндөн тавьж 2013 онд МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор Жендэрийн үндэсний хороо, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам хамтран “Эрэгтэйчүүд-хөгжилд” сэдэвт үндэсний чуулганыг зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах асуудлуудаар хэлэлцүүлэг явуулсан.

41. 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд эмэгтэй хүн ажиллахыг хориглосон ажил, хөдөлмөрийн жагсаалтыг оруулан 1999-2008 оны хооронд мөрдөж байсныг олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд 2008 онд цуцалсан. Энэ жагсаалт нь “эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх учраас тэдий эрүүл мэндийг анхаарч хөнгөн ажил хийлгэх ёстой” гэсэн хэвшмэл ойлголтыг улам бататгахад нөлөөлж байсан төдийгүй цалин өндөртэй уул уурхайн салбарт эмэгтэйчүүд ажиллах боломжийг хаахад нөлөөлж байсан юм.

42. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Гэр бүлийн тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиудад үр хүүхдээ төрүүлэх, өсгөх нь эмэгтэй хүнийг үүрэг, хариуцлага гэсэн хэвшмэл ойлголтонд тулгуурласан хуулийн заалтууд байдаг. Тиймээс дээрх хуулиудыг шинэчлэн боловсруулж байгаа ба эцэг, эхийн үүрэг хариуцлагын тэгш байдлын зарчимд нийцүүлэн өөрчлөхөөр ажиллаж байна.

43. Боловсролын яам бүх шатны боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрт хүний эрх, жендэрийн талаар ойлголт, мэдлэг олгох зорилгын дагуу 2014 оны 5 сараас их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт жендэрийн хичээлийг сонгох, шалгалт авч кредит цагаар тооцдог системтэй болсон.

44. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялангуяа эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах зорилгоор дурьдсан үйл ажиллагаануудыг хийж байгаа хэдий ч бодлого, хөтөлбөр, үйл

ажиллагаагаа дахин нарийвчлан боловсруулах, тухайн асуудлаар мэргэшсэн шинжээчид, байгууллагуудыг бодлогын түвшинд дэмжих, судалгаа, үнэлгээг үргэлжлүүлэн хийх, төсөв, санхүүжилтийг нэмэгдүүлэх, соёлын бодлогыг тодорхойлох шаардлага байсаар байна.

1.3 Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсооход авсан арга хэмжээ

(Конвенцийн 5-р зүйл)

45. Монгол улсын Засгийн газар 2005 онд Хүн худалдаалах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийг батлан, улмаар 2012 онд эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалах, биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсооход чухал ач холбогдолтой Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг Улсын Их Хурал баталсан ба Паломорын протоколд 2008 онд нэгдэн орсон.

1. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 58 дугаар тогтоолоор 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Монгол улсын стандарт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ыг баталсан бөгөөд энэхүү стандартын зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчидод үзүүлэх олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, уг үйлчилгээний орчныг тодорхойлох, улмаар тус үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд оршсон. Мөн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/93 тоот тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийг хамгаалах, халамжийн цогц үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ”-ний журам батлан хэрэгжүүлж байна.

47. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээллээр 2006-2013 онд буюу сүүлийн 8 жилд Хүн худалдаалах гэмт хэргийн 226 хохирогчтой 95 хэрэг бүртгэгдсэн байдаг. Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын мэдээллээр 2003-2014 онд буюу сүүлийн 12 жилийн байдлаар 554 хүн хүн худалдаалах хэргийн хохирогчоор тогтоогдсон байна. Хэргийн илрүүлэлт болон шүүхээр шийдвэрлэсэн байдалд нэлээд ахиц дэвшил гарч байгаа ч хүн худалдаалах гэмт хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинж чанартай байгаа тул бүрэн зөв тоон мэдээлэл гаргах явдал хүндрэлтэй хэвээр байсаар байна. Зарим амжилттай шийдэгдсэн кейсийг дурьдахад: “2009 онд Жижигээ хочит П болон нэр бүхий хүмүүс олон охидыг хулгайлах, дарамтлах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх замаар өөрийн гэр орон болон зочид буудлын өрөөг түрээслэн биеийг нь үнэлүүлж байсныг илрүүлэн 4 хүнийг хуулийн дагуу шийтгэсэн” гэсэн мэдээллийг тус ТББ-аас ирүүлсэн.

48. Засгийн газар эмэгтэйчүүд, хүүхдийг хил дамжуулан худалдаалах, биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоох асуудлаарх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх,

таслан зогсоох, хохирогчийг хамгаалах тогтолцоог чадавхижуулахад анхааран ажиллаж байна.

49. Түүнчлэн төрөөс иргэний нийгмийн болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр улс орны хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах, олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн кампанит ажлыг өрнүүлж ажилласан.

50. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу Хууль зүйн яамны дэргэд төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий дэд зөвлөл ажиллаж байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн мөрдөн байцаах газарт “Хүн худалдаалахтай тэмцэх тасаг” байгуулсан.

51. Арван жилийн өмнө хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр цөөн тооны төрийн бус байгууллагууд ажиллаж байсан бол өнөөгийн байдлаар 30 гаруй төрийн болон төрийн бус байгууллага, 12 хандивлагчид ажиллаж байна. Эдгээрээс 2 байгууллага хохирогчийг хамгаалах үйлчилгээг, 5 байгууллага хуулийн зөвлөгөө, 10 орчим байгууллага сургалт явуулж, чадавхи бэхжүүлэх үйлчилгээг үзүүлж байна.

52. Монгол улсын Засгийн газар, Гадаад харилцааны яам, Тагнуулын Ерөнхий газар, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ 2014 оны эхний хагас жилийн байдлаар гадаадад гэр бүлийн хүчирхийлэл болон хүний наймааны хохирогч болсон 36 эмэгтэйчүүдийг эх оронд нь буцаан авчирсан ба санхүүжилтийг иргэдэд туслах сангаас гаргасан байна. Энэхүү сангийн төсөв нь 2013 онд 280 сая төгрөг байсан бол 2014 онд 224 сая төгрөгөөр батлагдсан байна.

53. Мөн Хууль зүйн яамнаас хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар цагдаагийн байгууллагын ажилтангуудыг үе шаттай сургалтанд хамруулж байгаа ба “Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгааг эхлүүлээд байна.

54. Монгол улсын Засгийн газар 2010 онд БНХАУ-ын Макаогийн Засаг захиргааны онцгой бүсийн Засгийн газар хооронд “Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хамтран ажиллах” хэлэлцээрийг байгуулсан. Ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн талаар харилцан мэдээлэл солилцох механизм бүрдэж байна. Түүнчлэн ОХУ, БНХАУ, БНСА, БНКаУ, БНТУ-уудтай консулын зөвлөлдөх уулзалтуудыг 2011 оноос жил бүр зохион байгуулж, уулзалтын үеэр хүн худалдаалах болон мансуурах бодис зөөвөрлөх зохион байгуулалттай гэмт хэргийн талаар харилцан мэдээлэл солилцон цагдаа, тагнуулын байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулан, гэрээний хүрээн дэх үүргийн биелэлтээ дүгнэх зэргээр санал солилцон ажиллаж байна.

55. Үндэсний ТББ-ууд сүүлийн 10 жилд олон улсын байгууллагуудтай хамтран хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг улам эрчимжүүлж байна. Жишээлбэл, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ 2006 оноос АНУ-ын Азийн сан байгууллагын

дэмжлэгтэйгээр 1903 дугаартай итгэлийн утсыг ажиллуулж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөхөөс гадна дотоодод болон хил дамжуулан хүн худалдаалсан гэмт хэргийг хууль сахиулах байгууллагад мэдээлэхэд нь туслалцаа үзүүлдэг. Хүний аюулгүй байдлын судалгааны төв ТББ нь Монгол улс дахь Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүйсийн тэгш эрхийн төвийн дэргэд Улаанбаатар, Замын-үүд хилийн боомтод хүний наймаанаас хохирсон иргэдийг хамгаалах байрыг шинээр байгуулан тэдэнд сэтгэл зүйн засал хийх, нийгэмшүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Мөн тус байгууллага нь Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг боловсруулахад оролцсон нь төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны сайн жишээний нэг болсон.

56. Хүний наймааны хохирогч болсон иргэдийн, ядуу нөхцөл байдалтай ар гэрийн амьдралд туслах болон хохирогчдод эрх зүйн туслалцаа үзүүлэх өмгөөллийн үйлчилгээнд төрөөс сүүлийн жилд 7.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

## II ХЭСЭГ

2.1 Улс төр, нийгмийн амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцох боломжийг хангасан байдал

(Конвенцийн 7, 8-р зүйл)

57. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулиар улс төр, нийгмийн амьдралд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглосон.

58. Монгол улс нь парламентийн засаглалтай ардчилсан улс бөгөөд төрийн албанд сонгох, сонгогдох эрх хүн бүрийн өмнө нээлттэй ба шууд болон төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, нам, олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.

59. Өнгөрсөн 10 жилд эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд оролцох оролцоо сайжирсан хэдий ч, шийдвэр гаргах, удирдах албан тушаалд тэдний эзлэх хувь бага байсаар байна. Монгол улсын Засгийн газар эмэгтэйчүүдийн улс төр, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог 2015 он гэхэд 30 хувьд хүргэх зорилт тавьсан. (МХЗ-3) Энэ зорилтын хүрээнд 2011 онд УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн 27.2-т “Нам эвслээс нэр дэвшиж байгаа хүний 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна.” гэж зааснаар 2012 оны УИХ-ын сонгуульд өмнөх сонгуулийн жилтэй харьцуулахад нэг дахин олон буюу нийт нэр дэвшигчдийн 32.0 хувь нь эмэгтэйчүүд байсан ба тус сонгуулийн үр дүнд УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 14.47 хувьтай байна.

60. 2012-2016 оны УИХ-д 76 гишүүнээс 11 эмэгтэй гишүүн сонгогдоход 2012 оны УИХ-ын сонгуулийн хуулийн шинэчлэл тодорхой хувь нэр оруулсан гэж үзэж байгаа. УИХ-д эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдснээр эмэгтэй гишүүд бүлэг байгуулан ажиллаж байна.

## Зураг 1. УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Сонгуулийн жилээр

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо, 2012 он

61. Дээрх үр дүнд хүрэхэд иргэний нийгмийн байгууллага, ялангуяа эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын 20 гаруй жилийн тууштай үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлсэн. Мөн Жендэрийн эрх тэгш байдлын хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд 2005 оноос Жендэрийн үндэсний хороог байгуулан жендэрийн тэгш эрх, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн үр дүн гэж үзэж болно.

62. Бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангахад нилээд хүндрэл бэрхшээл оршсоор байна. Хамгийн бэрхшээлтэй асуудалд улс төрийн намууд мөнгө, санхүүгийн нөлөөлөлд автсан, дотоод ардчилал сул, гишүүдийн оролцоо хангалтгүй хэвлэл мэдээлэл нээлттэй, ил тод бус байдал орж байна. Нөгөөтэйгүүр эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхдаг олон нийтийн хандлага, соёл, уламжлал хэвээр хадгалагдаж байгааг эмэгтэйчүүдийн ТББ-аас хийсэн судалгааны тоо, баримт харуулж байна.

63. Аймаг нийслэл, сум дүүрэг, ба, хорооны шийдвэр гаргах удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, эзлэх хувь бага байна. Тиймээс Засгийн газраас орон нутгийн Иргэдийн хуралд сууж буй эмэгтэйчүүдийг чадавхижуулах ажилд илүү анхаарч байна. Цаашид Орон нутгийн өөрөө удирдах байгууллага болох Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох эмэгтэйчүүдийн суудлын тоог заасан квот тогтоох, аймаг, нийслэлийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг 40 хувьд хүргэхийг зорилго болон ажиллаж байна.

## Зураг 2. Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2004,2008,2012 оны сонгуулийн жилээр

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо, 2012 он

64. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн удирдлагын байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг бүх түвшинд 15-40 хувь доошгүй байхаар тогтоосон. Төрийн захиргаанд нийт 17.9 мянган албан хаагчид ажиллаж байгаагийн 57.4 хувь нь эмэгтэй байна. Тэдгээрээс тэргүүн түшмэлийн 27.6 хувь нь эмэгтэй байна.

65. 2014 оны байдлаар Засгийн газрын танхимд сайдаар 3, дэд сайдаар 2 эмэгтэй ажиллаж байна. Төрийн нарийн бичгийн дарга нарын 81.0 хувь нь эрэгтэй, 19.0 хувь нь (3) эмэгтэй байна. Яамдын удирдах албан тушаалтанд сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нарын 74.0 хувь нь эрэгтэйчүүд, 26.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргаар нэг ч эмэгтэй сонгогдож, томилогдоогүй.

66. Монгол улс дэлхийн 173 улстай дипломат харилцаатай бөгөөд 32 улсад элчин сайдын яам 2 байнгын төлөөлөгчийн газар, 9 Ерөнхий консулын газар, 3 консулын газар тус тус ажиллуулж байна. Монгол улсаас хилийн чанадад ажиллаж буй 32 элчин сайдаас 4 эмэгтэй байна.

67. Монгол улсын Засгийн газрын гишүүн, УИХ гишүүн, Байгаль орчин ногоон хөгжлийн сайд С.Оюун НҮБ-ын байгаль орчны асуудлаарх хорооны ерөнхийлөгчид нэрээ дэвшүүлэн монгол улсаас НҮБ-ын өндөр албан тушаалд эмэгтэй хүн сонгогдлоо.

68. Монгол улсад нийт 458 шүүгч ажиллаж байгаагийн 65.9 хувь нь эмэгтэй шүүгч байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 5 гишүүний 2 нь эмэгтэй байна. Дээд шүүхийн 25 шүүгчийн 12 нь эмэгтэй байна. Нийслэлийн шүүхийн ерөнхий шүүгчээр эмэгтэй хүн ажиллаж байна.

2.2 Эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдэд иргэний харъяаллын тухайд тэгш эрх олгосон байдал (Конвенцийн 9-р зүйл)

69. Монгол улсын Үндсэн хуулиар (15.1) иргэний харъяалал хийгээд харъяат болох, харъяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно гэж заасан. Монгол улсын иргэнийг хаъяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглодог.

70. Сүүлийн жилүүдэд монгол улсын иргэд гадаадын иргэдтэй гэрлэх байдал нэмэгдэх хандлагатай болж байна. Гадаадын иргэнтэй гэр бүл болж буй хүний 90 гаруй хувь нь эмэгтэйчүүд байна. Үүнтэй холбоотой гэрлэгсдийн гэрээ, гэр бүлийн өмчлөл, хүүхдийн иргэний харъяаллын асуудал үүсэн гарч ирж байна.

71. Төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаагаар “Гэр бүл зуучлал” нэрийдлээр охид, эмэгтэйчүүдийг гадаадын иргэнтэй тодорхой төлбөртэйгээр гэрлүүлэх үйл ажиллагаа явагдах болсон. Тэдний олонх нь хүчирхийлэл дарамтанд өртөж, боолчлолын байдалд орон, эрх нь зөрчигдөж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл өндөр байгааг харуулсан байдаг. Одоогоор манай улсад гэр бүл зуучлалын үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй байна.

### III ХЭСЭГ

3.1 Боловсролын салбар дахь жендэрийн тэгш байдлын хэрэгжилт

(Конвенцийн 10-р зүйл)

72. Монгол улсын Үндсэн хуульд “Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно” гэж заасан (16.1.7). Мөн Боловсролын тухай багц хуульд (2002), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд (2011) “Монгол улсад охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэйчүүд нь бага

боловсрол, бүрэн дунд, дээд, тусгай мэргэжлийн болон шинжлэх ухаан, технологийн гэх зэргээр бүхий л салбарт боловсролыг тэгш хүртэх эрхтэй”-г заасан. Засгийн газраас Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, МХЗ-уудыг (2005) боловсруулан ажиллаж байна.

73. Монгол улсын хүн ам бичиг үсгийн мэдлэгээрээ харьцангуй өндөр гэж ЮНЕСКО-ийн илтгэлүүдэд тусгасан байдаг. Статистик мэдээллээр 10-аас дээш насны нийт хүн амын 95.4 хувь нь бичиг үсгийн мэдлэгтэй ба эмэгтэйчүүдийн 95.5 хувь, эрэгтэйчүүдийн 95.3 хувь нь бичиг үсэгт тайлагдсан байна.

74. Монгол улсад хүн бүр боловсрох эрхтэй гэж заасан хэдий ч амьдралын нөхцөл, эрүүл мэндийн байдлаас хамаарч зорилтот бүлгийн, ялангуяа өсвөр насны залуу эхчүүдэд зориулсан боловсролын хүртээмж хангалттай бус байна. Үүнээс үүдэн Боловсрол шинжлэх ухааны яамны (Цаашид “БШУЯ” гэнэ.) дэргэд насан туршийн боловсролын төвийг байгуулан ажиллаж байгаа нь цаашид эмэгтэйчүүдийн насан туршийн боловсролыг дэмжихэд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

75. Бүх шатны сургалтын байгууллагыг төгсөгчдийн 59.8 хувь нь ерөнхий боловсролын сургууль, 15.5 хувь нь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 24.7 хувь нь их, дээд сургууль, коллеж төгсөгчид байна. Дээд боловсролын сургалтын байгууллагад 174.0 мянган оюутан суралцаж байгаагийн 58.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Боловсрол эзэмшиж байгаа хүйсийн харьцаа бага боловсролд 1.0, ерөнхий боловсролд 1.2, дээд боловсролд 1.4 байна. Боловсролын салбарын ажиллагсад, бүх шатны сургалтын байгууллагад суралцагсдын талаарх статистик мэдээлэл нь хүйсээр ангилан гардаг. Боловсрол, шинжлэх ухааны салбарт ажиллагсдын 78 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид

хүйс, боловсролын зэргээр

76. Эрэгтэйчүүд давамгайлсан уул уурхай, барилгын салбарт эмэгтэй хүн боловсрол олж авах нь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Монгол дахь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 57 төвөөс барилгын чиглэлээр нийт мэргэжил эзэмшиж, төгсөгчдийн 21 хувь нь эмэгтэйчүүд байна. Ихэнх эмэгтэйчүүд ирээдүйд цалин бага байх магадлалтай “уламжлалт” салбарт мэргэжил эзэмшсэн хэвээр байгаа юм.

3.2 Хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь жендэрийн тэгш байдлын хэрэгжилт

(Конвенцийн 11-р зүйл)

77. Монгол улс ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд ялгаварлахгүй байх зарчмыг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан. Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуульд (1992) “Хүн бүр ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэж заасан.



Үндсэн хуулийн энэ заалтыг биелүүлж, иргэн бүрт хөдөлмөр эрхлэн амьдрах бүх талын нөхцөл бололцоог хангахад төрийн бодлого гарган, тодорхой хөтөлбөрүүдийг боловсруулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хуульд (1999) эрэгтэй, эмэгтэй хүний хөдөлмөрийн харилцаан дахь тэгш эрхийн зохицуулалтыг хуульчилсан бөгөөд 7-р зүйлд аливаа ялгаварлал, хязгаарлалт, давуу байдал тогтоож болохгүйг заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах холбогдох заалтуудыг зөрчсөн тохиолдолд хянан шалгах, илрүүлэх, зөрчлийг арилгах ажлыг Мэргэжлийн хяналтын байгууллагын хөдөлмөрийн байцаагч гүйцэтгэдэг.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуульд (2001) хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлого, баримтлах зарчим, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхой болж, ажилгүйдлийг бууруулахад ач холбогдол өгсөн. Тус хуульд 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 45-наас дээш насны ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогч тухайн ажилтанд олгосон цалингийн 60 хувийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас буцаан олгохоор заасан.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар (2008) хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зохистой нөхцөл бүрдүүлэх, хяналт тавих асуудлыг зохицуулсан. Уг асуудлыг эрхэлсэн эрүүл ахуйн болон хөдөлмөрийн хяналтын мэргэжлийн алба ажилладаг ба үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөл, түүний үнэлгээг хийж байна. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөрт (2005-2010) хуулийн хүрээнд хэрэгждэг.

Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хууль (2011) нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлсон. Хуулиар хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг эрэгтэй эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажлаас халах, ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэхээр зохицуулсан. Уг хуулийг хэрэгжүүлэх салбар хоорондын бодлогыг боловсруулах ажлыг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо хариуцан, Хүний эрхийн Үндэсний комисс зэрэг байгууллагууд хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

Монгол улсын мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009) мэргэжлийн сургалт, техникийн боловсрол олгоход чиглэгдсэн. Энэ хуулийн хүрээнд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд байгуулагдаж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх тухай асуудал байгалийн нөөц баялаг, уурхай ашиглалттай холбоотой эрчимтэй яригдаж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр (2002-2015) нь хөдөлмөрийн харилцаан дахь хүйсийн ялгаварлыг арилгах, албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөрийн эрх зүйн харилцааг сайжруулах, хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн харилцааны хэвшмэл хандлагыг өөрчлөх ажлыг бүх шатанд зохион байгуулж ажиллах, үнэлгээгүй хөдөлмөр тэр дундаа хөдөөгийн эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг бууруулах зорилтуудыг хөдөлмөр эрхлэлтийн зорилт болгон тавьсан.

Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого (2006) нь албан бус хөдөлмөр эрхлэлтээс албан хэлбэрт шилжих санаачлага үйл ажиллагааг дэмжих зарчимд үндэслэж байна.

78. Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхаж үл болох зарчмыг үндэсний хууль, тогтоомжийн хүрээнд хориглож байгаа хэдий ч ялгаварлан гадуурхалтанд өртсөн тохиолдолд гомдлоо хаана гаргах, хэнд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхой бус байгаагаас хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалт байсаар байна. Энэ нь ажлын байрны сул орон тооны зар мэдээнээс эхэлж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргасан ажлын байрны талаарх зарыг судлаж үзэхэд ажлын байрны зар тутмын нэг нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байсан бөгөөд 90.7 хувь нь насны хязгаарлалт тавьсан байна.

79. Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль, бодлого, хөтөлбөрүүдэд хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг хориглосноос гадна тэгш эрхийг баталгаажуулахад чиглэсэн өргөн хүрээний үйл ажиллагааг ажлын байранд авч хэрэгжүүлэхийг шаардсан байдаг. Гэтэл нийгмийн хүрээнд хүмүүс зөвхөн жирэмсэн эсвэл хүүхэд асрах амралттай эмэгтэйг ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглодог болохыг л ихэвчлэн мэддэг. Харин олон нийтийн адил чанартай ажилд адил шан хөлс авах, ажлын байранд бэлгийн дарамтанд өртөхгүй байх гэх мэт ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын талаарх ойлголт сул байсаар байна.

80. 2005 онд ХЭҮК-оос хөдөлмөрийн харилцаанд нас, үндэс угсаагаар ялгаварлах хандлага байгааг тэмдэглээд “Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “энэ хууль болон холбогдох хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүнийг насаар ялгаварлахыг хориглоно” гэсэн хэсэг, мөн хуулийн 7.2-т заасныг баталгаажуулахын тулд 49.2-т “... эрэгтэй, эмэгтэй ажилтанд гэсний дараа “болон үндэс угсаагаар ялгаварлахгүйгээр...” гэсэн хэсэг нэмж оруулахыг зөвлөсөн боловч энэ нь Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдаагүй хэвээр байна.

81. Монгол улсын Засгийн газар 2005 онд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийг, 2008 онд Улсын их хурлаас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг баталсан. 2010 онд Хөдөлмөрийн хяналтын шинэчлэлийн үндсэн чиглэлийг баталж, хөдөлмөрийн хяналтын үйл ажиллагаанд нийгмийн түншлэгч байгууллагууд тэгш оролцох эрх зүйн орчин бүрдсэн нь хөдөлмөр эрхлэх тэгш байдлаар хангагдаж байгааг үнэлэх боломжийг олгосон. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2006-2010 оны мэдээллээс улсын хэмжээнд жилд дунджаар 420-480 үйлдэрлэлийн осол гарч,

түүнд 450-500 хүн өртөж, тэдгээрийн 15-20 орчим хувь нь нас барж, жилдээ 2000 гаруй хүн мэргэжлээс шалгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, тэтгэвэр тогтоолгодог. Гэхдээ хөдөлмөрийн чадвараа алдсан хүнийг тоог хүйсээр ангилж гаргаагүй байна.

82. 2013 оны байдлаар 15, түүнээс дээш насны ажиллагчид 1103.6 мянган хүн байгаагийн 47.5 хувь нь эмэгтэйчүүд, 52.5 хувь нь эрэгтэйчүүд байна. Үүнийг 2004 оны мэдээлэлтэй харьцуулахад эмэгтэйчүүд ажиллагсад 3.0 хувиар буурч, эрэгтэй ажиллагсадын тоо 3.0 хувиар өссөн байна. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж бөйгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь 47.8 байна. Энэ нь Монгол улс МХЗ-ын хүрээнд дэвшүүлсэн зорилтондоо хүрснийг харуулж буй үзүүлэлт юм.

83. Хөдөлмөрийн зах зээлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцоо тооны хувьд бага зөрүүтэй байдаг ч, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт дэх хэвтээ болон босоо ялгарал хүчтэй, цалин хөлс нь зөрүүтэй байна. Улсын хэмжээнд эрэгтэйчүүдийн дундаж цалин эмэгтэйчүүдийнхээс 14.3 хувиар илүү байна.<sup>[1]</sup> Сарын дундаж цалинг (2012 оны байдлаар улсын дундаж сарын цалин 557.6 мянган төгрөг) салбараар харахад хамгийн өндөр цалинг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, уул уурхайн салбарт авч байна. Цалин өндөртэй эдгээр салбарт эрэгтэйчүүд давамгайлж ажилладаг.

84. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн үнэлгээгүй хөдөлмөрийн ачаалал их байна. Ажлын нэг өдөрт зарцуулж буй цагийн тархалтаас харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.5 цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг бол хөдөөгийн эмэгтэйчүүд хотын эмэгтэйчүүд, хот, хөдөөгийн эрэгтэйчүүдээс нэг дахин илүү их цагийг зарцуулж байна.

85. Үндэсний хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшинг 2013 онд 61.9 хувьтай байгаагаас эмэгтэйчүүд 56.3 хувь, эрэгтэйчүүд 68.1 хувь эзэлж байна. Эдийн засаг хямралтай байгаа хэдий ч ажиллах хүчний оролцооны түвшинг сүүлийн 10 жилийн байдлаас харахад нилээд тогтвортой байгаа нь төрөөс хямралыг даван туулах хөтөлбөрүүдийг боловсруулж, ажлын байрыг хадгалах, нэг ажлын байранд богиносгосон цагаар хоёр хүн ажиллуулах, шинээр ажлын байр бий болгохыг урамшуулах зэрэг арга хэмжээнүүдийг авсантай холбоотой.

86. Ажилгүйдэл өнөөг хүртэл тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Ажилгүйдлийн түвшин 7.9 байна. 2004 онд бүртгэлтэй ажилгүй иргэд 35.5 мянга (44.8 хувь нь эрэгтэй, 55.2 хувь нь эмэгтэй) байсан бол 2013 онд 42.7 хувь (45.2 хувь нь эрэгтэй, 54.8 хувь нь эмэгтэй) болж өссөн.

Зураг 4. Ажиллах хүчний оролцоо, ажилгүйдлийн түвшин, хүйсээр, оноор

87. Ажил мэргэжил дэх жендэрийн ялгаварлал буюу цалин өндөртэй салбарт эрэгтэйчүүд илүү, цалин багатай салбаруудад эмэгтэйчүүд илүү олноор ажилладаг, олон хүүхэд төрүүлсэн зэрэг шалтгаанаар тэтгэвэрт

эрэгтэйчүүдтэй харьцуулахад 5-10 жилийн түрүүнд гардаг. Хүүхэд төрүүлж өсгөх, асрах зэргээр ажил, хөдөлмөр эрхлэх хугаанаас хасагддаг мөн ажиллаж байх үедээ ч гэр орны ажлын давхар ачааллыг үүрч байдгаас ажил мэргэжилдээ өсөх, цалин ихтэй өндөр албан тушаалд хүрэх боломж бага байна гэж дүгнэсэн байна.(Зохистой Хөгжлийн Жендэр Төв ТББ, Монгол улсын Хөдөлмөрийн эрх зүйд үл ялгаварлан гадуурхал, жендэрийн тэгш байдлыг дэмжих нь судалгаа, 2012 он)

88. Эцэг эхэд гэр бүлийн үүргээ хэрэгжүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх, олон нийтийн амьдралд оролцох зэргээр гэр бүл, нийгмийн хүрээнд ажиллах боломж хязгаарлагдмал байна. Ялангуяа цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгаа болон 2008-2009 оны хичээлийн жилээс дунд боловсролыг 12 жил болгож, 6 настай хүүхдүүд сургуульд сурах болсноор эмэгтэйчүүд хүүхдээ асран халамжлах ажлын ачаалал улам нэмэгдэж байна. Одоо мөрдөж байгаа Хөдөлмөрийн тухай хуулиар энэ асуудлыг шийдэх зохицуулалт байхгүй байгаагаас ялангуяа хөдөөгийн малчин өрхийн эмэгтэйчүүд мал аж ахуйн ажлаасаа хөндийрөн сумын төвд хүүхэдтэйгээ амьдрах нь нэмэгдэж байна. Засгийн газар хот суурин газруудад ажлын уян хатан цаг, зайнаас ажиллах боломж, хүүхэд асрах байгууллагууд шаардлагатай байгааг анхаарч ажиллаж байна.

89. Хөдөлмөрийн хуулийн 40.1.3-т ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэрт авах эрх үүсэхийг заасан. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар (1994) өндөр насны тэтгэвэр авах эрх 20 жилээс доошгүй жил тэтгэвэрийн даатгалын шимтгэл төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэйд нээгддэнэ. Мөн 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэвэрийн даатгалд төлсөн бол 50 настайдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

90. Эмэгтэйчүүдийн ТББ-уудаас эмэгтэйчүүд тэтгэвэрт эрт гарах нь удирдах албан тушаалд ажиллах тэдний боломжийг багасгаж, улс төрийн эрх, чөлөөгөө эдлэхэд нь “шилэн тааз” болж байна гэж үздэг. 2009 оны ажиллах хүчний судалгаанаас үзэхэд 50-иас дээш насны эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн зонхилох шалтгаан нь эрт тэтгэвэрт гарах асуудал байна. Эдгээр эмэгтэйчүүдийн бараг 30 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байгаа нь тэтгэвэрт гарсан нь тэдний сонголт биш байгааг харуулж байна. Тэтгэвэрт эрт гарч байгаа нь орлогын хэмжээнд нөлөөлж байна.

91. Тэтгэвэрийн доод хэмжээ 2014 оны 6 сарын байдлаар 207.3 мянган төгрөг байна. Хувь тэнцүүлсэн тэтгэвэрийн доод хэмжээ 172.2 мянган төгрөг, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч иргэний дундаж тэтгэвэр 168,0 байна.

92. 2012 оны 9 дүгээр сард Засгийн газраас “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийг батласан нь тэтгэвэрийн хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон. Энэ хуулийн зорилт нь өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар 1990-2000 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцуулах асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн. 1990-2000 оны нийгмийн шилжилтийн явцад ажил олдохгүйн улмаас

ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй байснаас орлогогүй, тэтгэврийн даатгалд хамрагдаагүй 494.8 орчим мянган иргэн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ өнгөрсөн онд нөхөн тооцууллаа.

93. Мөн энэ хуулийг дагалдах журамд 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эсхүл олон жил ажилласан нөхцлөөр нас харгалзахгүйгээр хөдөлмөрийн хэвийн бус нөхцлөөр 1991-1994 онд тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийг хамруулахаар болсон. 1991-1994 онуудад 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхчүүд болон 27 жил ажилласан эмэгтэйчүүдийг нас харгалзахгүйгээр тэтгэвэрт гаргаж байсан. Энэ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн баримжаатай эдийн засагт шилжих үед олон үйлдвэрүүд хаалгаа барьж, иргэд олноороо ажилгүй болж байсантай холбоотойгоор ажлын байрны хомсдолоос болоод хөдөлмөрийн насны хүн амыг ялангуяа эмэгтэйчүүдийг олноор нь тэтгэвэрт суулгаж байсан. Энэ үед 36 настай залуу эмэгтэйчүүдийг тэтгэвэрт гаргасан. Эдгээр иргэд одоо хамгийн доод хэмжээний тэтгэвэр авдаг. Урдчилсан байдлаар 41 мянган иргэн энэ бүртгэлд хамрагдагдсан ба тэдний 82 хувь нь эмэгтэйчүүд байна. 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн холбогдох тэтгэврийн нэмэгдлийг иргэдэд тооцож олгосноор тэтгэврийн ялгаатай байдлыг арилгахад хувь нэмэр үзүүлнэ гэж үзэж байна.

94. “Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг байдал, ядуурал” тайланд дурьдсанаар Монгол улсын нийт ажиллах хүчний 30-35 хувь нь албан бус секторт ажиллаж байна. Хувиараа арилжаа наймаа хийх, жижиг бизнес эрхлэх нь эхлэлийн бага хөрөнгө шаарддагаас гадна ажиллах цагаа өөрөө зохицуулах боломжтой тул ялангуяа эмэгтэйчүүдийг татах хүчин зүйл болж байна. Энэ салбарт эмэгтэйчүүд олноор ажиллаж байгаа бөгөөд тэдний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин нь тодорхой бус хэвээр байна.

### 3.3 Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт

(Конвенцийн 4,12-р зүйл)

95. Монгол улсын Үндсэн хууль “Иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлэгийн тусламж авах эрхтэй” гэж заасан (16.6) ба Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх заалтыг тусгаж, эрүүл мэндийн чиглэлээр төрөөс баримтлах” 3 бодлого, 13 хууль, эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө, 20 гаруй стратеги эдгээртэй уялдан гарсан бодлогын баримт бичиг хэрэгжиж байна.

96. Гэр бүлийн төлөвлөлтийг оролцуулан эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох үүднээс 1997 оноос Нөхөн үржихүйн эрүүл мэндийн (Цаашид “НҮЭМ” гэнэ.) Үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд “НҮЭМ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” үндэсний стратегийг батлуулаад байна. Засгийн газраас НҮЭМ-ийн нэн шаардлагатай эм, хэрэгслээр хангахад

зориулж 2010 онд 85 сая, 2011 онд 100 сая, 2012 онд 150,0 сая, 2013 онд 180,0 сая, 2014 онд 210 сая төгрөгийг улсын төсөвт тусган батлуулсан бөгөөд худалдан авах, түгээх ажлыг Эрүүл мэндийн яамнаас (Цаашид “ЭМЯ” гэнэ.) зохион байгуулж байна. ЭМЯ-наас эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай нөхөн үржихүйн эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоог жил бүр хийж, НҮБ-ын Хүн амын сангаас жил бүр 300.000 ам. долларын эм, хэрэгслийг авч, Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилж байна.

97. Үндэсний статистикийн хорооноос нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний судалгааг жил бүр явуулдаг бөгөөд 2008 оны судалгаагаар хот, хөдөө, боловсролын түвшин, орлого, насны зөрүүнээс үл хамааран эрэгтэй эмэгтэй хүмүүсийн 96-98 хувь нь “Жирэмслэхээс хамгаалах нийтлэг аргуудыг мэддэг” гэсэн дүн гарсан. Гэр бүл төлөвлөлтийн аргын талаарх мэдлэгийн түвшин хангалттай байгаа хэдий ч мэдлэгээ дадал болгож буй байдал хүн амын дунд хангалтгүй байна. Эмэгтэйчүүд гэр бүл төлөвлөлтийн аргыг төдийлөн хэрэглэхгүй байгаа нь үр хөндөлтийн түвшин буурахгүй байгаа үзүүлэлтээс харагдаж байгаа ба үр хөндөлтийн 70 орчим хувийг давтан үр хөндөлт эзлэж байгаа нь анхаарал татаж байна. Гэр бүл төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээний чанар, арга хэрэгслийн хүртээмж зорилтот бүлэгт хязгаарлагдмал байгаа асуудлууд хэвээр байна.

98. “Эхийн эндэгдлийг бууруулах” хоёр удаагийн стратегийг 2001-2005, 2006-2010 онд, 2005 оноос “Эх хүүхдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх”, “Эх нярайн эрүүл мэнд” 2011-2015 үндэсний стратегийг хэрэгжүүлсэнээр эх, нярайд үзүүлэх тусламжийн хүртээмж, чанар сайжирч байна. Эхийн эндэгдэл<sup>[2]</sup> 2000 онд 166.2 байсан нь 2008 онд 96.7 болж буурснаар Монгол улс эхийн эндэгдэл өндөртэй орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд шилжсэн улмаар жил дараалан буурч, 2013 онд 46.2 болсон нь манай улсад эхийн эндэгдэл 1990 оны түвшингээс бараг 4.7 дахин буурч, 2015 онд хүрэхээр төлөвлөсөн Мянганы хөгжлийн зорилтод хүрч, улмаар эхийн эндэгдэл өндөртэй орноос дунд зэрэгтэй орны түвшинд хүрэхээр байна. Улсын хэмжээнд эхийн амрах байр 341 ажиллаж, нийт амарвал зохих эхчүүдийн 74.9 хувь нь эхийн амрах байраар дамжин төрсөн байна

99. Эхийн эндэгдэлд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байгаагийн дотор жирэмслэлт, төрөлтийн талаарх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгаа явдал юм. Тухайлбал жирэмсний эрт үед хяналтад орохын ач холбогдол, жирэмсний болон төрөх, төрсний дараах үеийн хүндрэлүүдийн талаар мэдээлэл дутмаг, хувь хүн, гэр бүлийн гишүүд өөрийнхөө болон гэр бүлийнхний эрүүл мэндийг хамгаалах талаарх мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэх ажлыг хүн амын бүлэг бүрийн онцлогт тохирсон хэлбэрээр эрчимтэй явуулах хэрэгцээ байна. Нөгөөтэйгүүр эмчийн зөвлөгөөг авдаг ч амьдралын боломж бололцоо муугаас дагаж мөрдөхгүй байх тохиолдлууд байна.

1. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед зохих үйлчилгээгээр хангаж, шаардлагатай тохиолдолд төлбөргүй үйлчилгээ үзүүлж, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг хүрэлцэхүйц хоол тэжээлээр хангах асуудлыг

Эрүүл мэндийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд тусган зохицуулж байна. Жирэмсний болон төрөхөөс өмнөх, төрсний дараах үед тус бүр 45 хоногт эмчийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар/-ний зардлыг төрөөс хариуцдаг. Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр олгож байна.

2. Гэхдээ төлбөргүй тусламж, үйлчилгээ үзүүлэх хуулийн заалтаар олгож буй тэтгэмж, эрүүл мэндийн даатгалаас олгогдож буй зардал бодит тусламж, үйлчилгээний өртөгт хүрдэггүй байгаа билээ. Нийгмийн халамжийн сангаар олгож буй мөнгөнөөс өөр орлогогүй тохиолдолд жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд хүрэлцэхүйц хоол тэжээлээр хангагдах нөхцөл хязгаарлагдмал байсаар байна. Энэ нь бүс нутгуудад ялгаатай харилцан адилгүй байна.
3. Эрүүл мэндийн салбарт төсвийн 20 гаруй хувийг зарцуулдаг ба 2013 оны байдлаар эрүүл мэндийн байгууллагад нийт 45.0 мянган хүн ажиллаж байгаагийн 36.3 мянган нь эмэгтэйчүүд байна.

3.4 Эдийн засаг, нийгмийн бусад салбарт эмэгтэйчүүдийг ялгаварлах байдлыг устгахад чиглэсэн үйл ажиллагаа

(Конвенцийн 13-р зүйл)

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд эдийн засаг, нийгмийн салбарт жендэрийн ялгаварлан гадууралтыг хориглосон.
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар эдийн засгийн хүрээн дэх жендэрийн тэгш байдлын баталгааг хангасан. (9 дүгээр зүйл) Жендэрийн үндэсний хорооноос 2014 оныг “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдэл, манлайллыг сайжруулах” жил болгон ажиллаж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд Үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг төрийн бус байгууллага, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэж буй эмэгтэйчүүдийг оролцуулан зохион байгуулж, 2014 оны 6-н сард Эмэгтэйчүүдийн эдийн засгийн баталгааг хангах, манлайлалыг нэмэгдүүлэх бодлогын дэд стратегийг боловсруулж баталсан. Жендэрийн үндэсний хорооноос эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдэл, чадавхийг сайжруулах дэд стратеги, хөтөлбөрийг боловсруулан ядуурлаас гаргах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, нийгэмд эзлэх байр суурийг нь нэмэгдүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар ажиллаж байна.
3. Өнөөгийн Монгол улсын эдийн засгийн өсөлт нь хүн амын ядуурлыг бууруулахад нөлөөлсөнгүй. Харин ч ядуу болон чинээлэг хүн амын орлогын ялгаа ихээр нэмэгдэж, эмэгтэйчүүд, хүүхдүүд ядууралд илүү өртөж байна. Засгийн газраас эдийн засгийн боломжийг бий болгох, үл хөдлөх хөрөнгө эзэмших, нийгмийн халамж үйлчилгээг хавтгайруулан олгох бус өрхийн амьжиргааны баталгаат түвшингээс доогуур амьдарч байгаа өрх толгойлсон олон хүүхэдтэй эмэгтэйчүүдэд олгох бодлогыг анхаарч хэрэгжүүлж байна. 2014 оны байдлаар нийт өрхийн 17 хувийг эмэгтэй тэргүүнтэй өрх эзэлж байна.

4. Хөдөөгөөс хот, төв суурин газар нүүн шилжих хөдөлгөөний эрчимжиж байгаа нь суурин газрын тэр дундаа Улаанбаатар хотын дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний ачааллыг нэмж, агаар хөрсний бохирдол бараг дээд цэгтээ хүрэхэд нөлөөлж байна. Өнөөгийн шилжих хөдөлгөөн нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амьжиргааны эх үүсвэр хайх гол арга зам нь болжээ. Ийн шилжих хөдөлгөөн үүсч, явагдахад хот суурин газар, хөдөө орон нутгийн хоорондох нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин дэх ялгаатай байдал, байгалийн гамшиг гол түлхэгч хүч болж байна. Шилжих хөдөлгөөнд оролцогсдын 64 хувь нь гэр бүлийн гишүүнээ даган орж ирсэний дийлэнх нь эмэгтэйүүд (69.0 хувь) байна. Шилжигч эмэгтэйчүүд нь ажилгүйдэл, ялгаварлан гадуурхалд илүүтэй амархан өртдөг учраас тэдний олонхи нь тухайн үедээ ямар ч төрлийн ажил хийхээс өөр аргагүйд хүрдэг байдал нь тэднийг эмзэг болгож, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж байна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн асуудлыг нийгмийн хамгааллын бодлогоор шийдвэрлэдэг. Монгол улсын хүн амын 3.8 хувь нь буюу 96.3 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 52.7 мянга нь эрэгтэй, 34.5 мянга нь эмэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, нийгмийн гишүүн байх эрхийг баталгаажуулах асуудал тулгамдсан асуудлын нэг байсаар байна.

### 3.5 Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг анхааран үзсэн байдал

(Конвенцийн 14-р зүйл)

1. Нийт хүн амын дунд эзлэх хөдөөгийн хүн амын эзлэх хувь 2004 – 2009 онуудад 39.3 байсан бол 2009 оноос хойш 34.9 хувь болж буурсан байна.
2. Монголын хөдөөгийн эмэгтэйчүүд байгаль, цаг уурын эрс, тэс уур амьсгал, нутаг нутгийн өвөрмөц онцлог, нөхцөл байдалдаа зохицон, уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаа өнөөг хүртэл эрхлэн амьдарч байна. Мал аж ахуйн салбар цаг агаар, ялангуяа ган, зуднаас ихээхэн хамааралтай хэвээр байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хүний оролцоотой экосистемийн өөрчлөлтүүдээс үүдэн нүүдэлчдийн уламжлалт амьдралын хэв шинж өөрчлөгдөж байгаа нь малчин эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг дордуулахад нөлөөлж байна. Энэ нь ядуурал, бэлчээрийн хомсдол, шилжих хөдөлгөөн, уул уурхайн хөгжил зэрэг асуудлуудтай шууд холбоотой байна.
3. Монгол улс нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганаар “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай” тогтоолыг санаачлан батлуулж бусад улс орныг уриалан хөдөөгийн эмэгтэйчүүдийн асуудлыг анхааран ажиллахыг чармайж байна.
4. Хөдөө нутагт эмэгтэйчүүд гэр бүлийн болон өрхийн бизнест цалин хөлсгүйгээр ажиллаж байгаагийн зэрэгцээ малчин эмэгтэйчүүд хоногийн 12-14 цаг ажиллаж байна. Тиймээс Засгийн газраас малчин эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг сайн дурын нийгмийн даатгалд хамрагдах боломжийг бий болгох чиглэлээр ажиллаж байна.
5. Малчин эмэгтэйчүүдийн хувьд эмнэлэгийн тусламж үйлчилгээ авах, тэр дундаа алслагдсан малчин эхчүүдийг төрөхөөс өмнө амруулж эмнэлгийн



тусламжид ойр байлгахад төрөөс анхаардаг. Монгол улсын Засгийн газар социалист нийгмийн үеэс хөдөөд эхийн амрах, амаржих байрыг тогтмол ажиллуулж эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн тусламж үзүүлэх үйлчилгээнд эсэн мэнд амаржих нөхцлийг бүрдүүлж чадсан юм. Сум, багт амьдарч байгаа төрөх эхчүүдийг (60-80 хувь) улсын амаржих газарт амаржуулах, шилжүүлэх үйлчилгээг хэрэгжүүлснээр эхийн эндэгдлийг тууштай бууруулахад үр дүнгээ өгч байна.

6. Түүнчлэн 2013 оны байдлаар, бүх аймагт зайн оношлогооны тоног төхөөрөмжийг суурилуулж, эмч нараа бэлтгэж, нэгдсэн телемедициний сүлжээнд холбосон арга хэмжээ нь алслагдсан хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд, нялхас, хүүхдүүдэд нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн туслалцааг хугацаа алдалгүй авах боломжийг бүрдүүллээ.
7. 2009 оноос хөдөөгийн эмэгтэйчүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, тэдний мэдлэг чадварыг сайжруулах чиглэлээр тусгай сургалтуудыг зохион байгуулж, 2012 оноос эмэгтэй малчид хоршоо, бүлгүүдийн гишүүн болох нь нэмэгдэж байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 1 кг ноос тутамд 2000 төгрөгийн татаас тушаасан хоршооны гишүүдийг урамшуулдаг болсон нь хөдөөгийн эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх, тэдний мэдлэг, чадварыг сайжруулах чиглэлд авч байгаа бодитой арга хэмжээ юм.
8. Засгийн газраас хөдөө нутагт хүнсний ногоо тариалж буй иргэдийг дэмжин, тусгайлан борлуулалт хийх боломжийг дэмжин 2012 оноос хойш жил бүрийн намар Улаанбаатар хот, суурин газарт үзэсгэлэн худалдаа ажиллуулж, хөдөөгийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хотын оршин суугчдыг хямд, чанар сайтай эко хүнсээр хангах ач холбогдолтой ажил болж байна.
9. Байгаль орчин ногоон хөгжлийн яам “Ногоон хөгжлийн болон Байгаль орчны салбарын жендэрийн стратеги”-ийг баталлаа. Энэхүү баримт бичигт байгаль орчны доройтлоос хөдөөгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх, тэднийг чадавхжуулах арга хэмжээг тусгасан.

#### IV ХЭСЭГ

##### 4.1 Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн иргэний харилцаа дахь адил тэгш байх эрхийн хэрэгжилт (Конвенцийн 15-р зүйл)

1. Үндсэн хуульд (1992) “Эмэгтэй, эрэгтэй хүн бүр газар, бусад төрлийн өмч эзэмших, захиран зарцуулах тэгш эрхтэй” гэж заасны дагуу 2005 онд баталсан Газар өмчлүүлэх тухай хуулиар өрх бүрт өөрийн хашааны газартай байх боломж нээгдсэн. Гэсэн хэдий ч газрын эрхийн бүртгэл нь өрхийн тэргүүн гэдгээр эрэгтэй хүний нэр дээр бүртгэгдэж байсан. Харин 2008 онд тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж иргэн бүрт газар өмчлөх эрхийг нь баталгаажуулсан. Энэ хуулийн дагуу эмэгтэйчүүд газар өмчлөх, хувьчлах харилцаанд оролцох боломжтой болсон. Өнөөдөр монгол улсын эрэгтэй, эмэгтэй иргэн бүр 0,07 га газрыг өмчлөх, 1 га хүртлэх газрыг аж ахуйн зориулалтаар эзэмших эрхтэй.

2. Гэхдээ аж ахуйн зориулалтай газрыг өрхийн тэргүүний нэр дээр бүртгэдэг байдал хадгалагдсан хэвээр байна. Судалгаагаар 8 аймагт бүртгэлтэй газрын гэрчилгээг регистрийн/иргэний бүртгэлийн/ дугаараар ангилахад 65 хувь нь эрэгтэй, 35 хувь нь эмэгтэй хүний нэр дээр бүртгэлтэй байсан байна. Хөрөнгийн эрхийн үнэлгээ судалгааны дүнгээс харахад хувьчлагдаагүй газрын байршлыг олж тогтоох, баталгаажуулах зэрэгт зардал ихээр гардаг, мөн газар өмчлөх гэрчилгээ авахын тулд тухайн газраа хашаа барих, үл хөдлөх хөрөнгө барьсан байхыг шаардаж байгаа зэрэг нь эмэгтэйчүүдийг газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саа бэрхшээл болж байна гэжээ.
3. Аливаа өмч эзэмшихэд тохиолдож байгаа жендэрийн ялгаварлал нь эмэгтэйчүүд хувираа хөдөлмөр, бизнес эрхлэх сонголтыг хязгаарлагдмал байдалд оруулахад нөлөөлж байна. 2008 оноос жижиг, дунд үйлдвэр эрхлэлтийг дэмжих бодлогыг улсаас эрчимтэй хийж байгаа ч, эмэгтэйчүүдийн оролцоо бага байна.
4. Иргэний хуулийн 126 дүгээр зүйлийн 126.2.3-д “Ногдол хувь, үнэт цаасыг дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөнд тооцох”-оор заасан ч шүүх гэрлэлтийг цуцлах асуудлыг шийдвэрлэхдээ нөхөр/эхнэрийн нэр дээр буй компанийн хувьцааг гэр бүлийн дундын өмчлөлд тооцолгүй “Компанийн тухай хууль”-иар зохицуулж, эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүдийн байгаа хувьцааны асуудлыг шийдвэрлэхгүй орхигдуулж байна. Үүнийг Засгийн газар анхааралдаа авч дээрх хуулиудыг боловсронгуй болгоход анхаарч байна.

#### 4.2 Гэрлэлт, гэр бүлийн харилцаа дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 16-р зүйл)

1. Монгол улсын Үндсэн хуулинд “18 нас хүрсэн монгол улсын эрэгтэй, эмэгтэй иргэн сайн дурын үндсэн дээр гэрлэлтээ бүртгүүлж болно” гэж заасан. Монгол улсад гэр бүлийн харилцаа, гэр бүлийн гишүүдийн тэгш байдлыг “Гэр бүлийн тухай” хуулиар баталгаажуулан хэрэгжүүлж байна. Хуулийн дагуу “Гэр бүл, эцэг, эх, хүүхэд нь Монгол Улсын төрийн хамгаалалтад байх” ба “Эрэгтэй, эмэгтэй хоёрын гэрлэлт сайн дурынх байх”, “Гэрлэгчид тэгш эрхтэй” байх, “Гэр бүлийн дотоод асуудлыг гэр бүлийн гишүүд харилцан тохиролцож шийдвэрлэх”, “Гэр бүлийн бусад гишүүдийн тэгш эрх болон бие даасан байдлыг хүндэтгэх”, “Гэрлэлтийг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж баталгаажуулснаар хүлээн зөвшөөрнө” гэж тус тус заасан.
2. Монгол Улсад эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна. Гэр бүлийн харилцаанд үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бусад байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглодог.
3. Анхны гэрлэлтийн дундаж нас эмэгтэйд 24.2, эрэгтэйд 26.2 байгаа нь 10 жилийн өмнөхтэй харьцуулахад гэрлэх нас нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн гэрлэлтийн тоо буурч байна. Тухайлбал, 2013 оны байдлаар гэрлэлт 15.8 мянга, цуцлалт 3.5 мянга байгаа бөгөөд гэрлэлт хамгийн өндөр байсан 2006 онтой харьцуулахад 67.8 хувиар буурч, гэр бүл цуцлалт 2.5 хувиар нэмэгдсэн байна.

4. Гэр бүлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудад нөхөн үржихүйн шийдвэр гаргах эрх нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр гэр бүл болох, гэр бүлээ төлөвлөх, төрүүлэх хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацаа, хүүхэд төрүүлэх газраа сонгох, энэ шийдвэрээ гаргахад хэрэгцээт мэдээлэл, эрүүл мэндийн тусламж авч сайн дураар сонголт хийх талаар тусгасан. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Эцэг эх нь үр хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэйг, гэрлэлтээ цуцлуулсан нөхөр буюу эхнэрийн тэжээн тэтгүүлэх эрх үргэлжлэх тухай” хуульчилж өгсөн.
5. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны (2013) урьдчилсан дүнгээр ямар нэг жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга хэрэгслийг мэддэг 15-49 насны хүн амын хувь эрэгтэй 98.3, эмэгтэй 99.6 гэсэн тоо гарч байна. Түүнчлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл авсан 15-49 насны хүн амын хувь эрэгтэйд 45.4 хувь нь эрэгтэй, 52.4 эмэгтэй байна.
6. Хүн амын бодлого төлөвлөлт өнөөгийн өрхийн олон төрлийн бүтэц болох нийлмэл гэр бүлүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, хоёроос дээш үеийнхэн амьдардаг гэр бүлүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн талаарх бодит асуудлуудыг уламжлалт таамаглал дээрээ үндэслэн хийж байгаагаас жендэрийн харьцаа, гэр бүлийн бүтцэд гарч буй өөрчлөлтийг төдийлөн сайн харгалзаж үзэж чадахгүй байдалд хүргэж байгааг анхаарах хэрэгтэй болж байна.
7. Иймд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас Хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлогыг илүү Гэр бүлийн хөгжилд суурилсан хандлагаар боловсруулан төслийг УИХ-д өргөн бариад байна. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн төсөлд гэр бүлийн хөгжил, хүүхдийн эрхэд суурилсан зарим өөрчлөлтүүдийг оруулсан ба одоогийн Хүүхдийн төлөө үндэсний газрыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн агентлаг болгож нийслэл, аймаг, орон нутагт Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан бүтэцтэй байхаар тусгасан.
  1. Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд зөвлөгөө өгөх төвд тавигдах нийтлэг шаардлага бүхий стандартыг 2013 онд батлуулж, гэр бүлд туслан зөвлөх үйлчилгээ үзүүлж буй төвүүдийн ажилтны үүрэг, үйл ажиллагааны чиглэл, агуулга хэм хэмжээг тогтоож өгсөн. Гэр бүлийн талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр бүлд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг онлайн хэлбэрээр хүргэх боломжийг бүрдүүлэх үүднээс [www.ger-bul.info](http://www.ger-bul.info) домайн ажиллуулж байна.

---

[1] УСХ, Цалингийн түүвэр судалгаа

[2] 100 000 амьд төрөлтөнд ногдох эндсэн эхийн тоо